



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд эргүүл, хамгаалалтад томилогдсон албан хаагчдын талаар авах арга хэмжээний тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 27 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 785 тоотыг тус тус үндэслэн 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийг дуустал хугацаанд тус байгууллагаас эргүүл, хамгаалалтад томилогдон ажиллаж байгаа албан хаагчдын ажиллах нөхцөлийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Эргүүл, хамгаалтад томилогдон ажиллаж байгаа албан хаагч нарт эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, иргэдтэй зөв боловсон харьцаж хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

2. Эргүүл, хамгаалтад томилогдон ажиллаж байгаа албан хаагчдыг амны хаалт, ариутгагч болон дархлаа дэмжих хүнсээр хангаж, холбогдох зардлыг зохих эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Дашпүрэв/-т зөвшөөрсүгэй.

3. Эргүүл, хамгаалтад томилогдон ажиллаж байгаа албан хаагчдыг ээлж солих үед албаны автомашинаар үйлчлэх арга хэмжээг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Б.Дашпүрэв/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын тосны салбарын асуудал хариуцсан орлогч дарга /Ц.Эрдэнэбаяр/-т даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН